

## Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны талаар

### 1. Тусгай зөвшөөрлийн хууль эрх зүйн орчин

#### а. Олон улсын конвенци, багц стандарт :

Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай протоколын Ерөнхий хавсралтын 8 дугаар бүлгийн **“ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ГУРАВДАГЧ ЭТГЭЭД ХООРОНДЫН ХАРИЛЦАА”** хэсгийн:

8.1 Стандарт “Холбогдох этгээд нь гаалийн байгууллагатай өөрөө шууд харилцах эсхүл өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдээр дамжуулан харилцах эсэхийг сонгож болно.”

8.2 Стандарт “Бусад этгээдийн өмнөөс гаалийн байгууллагатай харилцах гуравдагч этгээдийн нөхцлийг үндэсний хууль тогтоомжид заасан байх бөгөөд мөн гаалийн болон бусад татварыг барагдуулах болон явцын дунд гарах аливаа хариуцлагын талаар хүлээх үүргийг заасан байна.” гэж тус тус заасан бөгөөд Монгол улс уг конвенцид 2006 онд нэгдэн орсон болно.

#### б. Монгол улсын хууль тогтоомж:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 хэсэг, 15.4.7 дахь заалт болон Гаалийн тухай хуулийн 66.2. дахь хэсэгт “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд уг зөвшөөрлийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.” гэж тус тус заасан. Уг зөвшөөрлийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 6.1 хэсгийг үндэслэн 3 жилийн хугацаатайгаар олгож, 6.2 хэсэгт заасны дагуу мөн хугацаагаар сунгана.

Гаалийн байгууллага гаалийн зуучлагч болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд Гаалийн тухай хуулийн зургаа, долдугаар дэд бүлэг болон Гаалийн ерөнхий газрын даргын 2010 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын дагуу хяналт тавина.

### 2. Гаалийн зуучлалын тухай ерөнхий ойлголт

Гаалийн үйл ажиллагааг ил тод, ойлгомжтой, нийтэд дөхөм болгох, гаалийн бүрдүүлэлтийг чирэгдэл багатай түргэн шуурхай гүйцэтгэхэд гаалийн байгууллагын үйл ажиллагаанаас гадна гааль бизнес эрхлэгчдийн дунд зуучлах үүрэг бүхий гаалийн зуучлагчийн институцийн үйл ажиллагаа чухал юм.

Гаалийн зуучлал нь барааны ангиллыг тодорхойлох, барааны гаалийн үнийг тодорхойлох, барааны тоо хэмжээ, жинг гаргах, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн горимыг сонгох, гаалийн мэдүүлгээр барааг гаалийн байгууллагад мэдүүлэх, бараанд ногдох гаалийн болон бусад татварыг төлөх, гаалийн бүрдүүлэлт хийж дууссан тухай зуучлуулагч этгээдэд үр дүнг мэдээлэх гэх мэт барааг гаалийн хяналтад орохоос эхлэн гаалийн хяналтнаас гарах бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх чухал үүрэгтэй.

	Асуулт	Хариулт
1	Зөвшөөрлийн нэр	Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх
2	Зөвшөөрөл олгогч байгууллагын нэр	Сангийн яам
3	Эрх зүйн үндэслэл (хууль, эрх зүйн актын нэр, холбогдох зүйл, заалт тус бүрийг текстээр нь тодорхой бичнэ.)	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.4. Санхүү, эдийн засгийн чиглэлээр: 15.4.7 дахь заалт гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх; Гаалийн тухай хууль II хэсэг. Зургадугаар бүлэг. Долдугаар дэд бүлэг 66.2. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд уг зөвшөөрлийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.
4	Энэ зөвшөөрлийг авахад аж ахуй эрхлэгчээс заавал бүрдүүлэх ёстой баримт бичгийн жагсаалт	Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4-т зааснаас гадна Гаалийн тухай хуулийн 67.1, 70.2 -т заасан бичиг баримт бүрдүүлж гаалийн удирдах төв байгууллагад ирүүлнэ: Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл</li> <li>• 2-оос доошгүй гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй байх</li> <li>• улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>• улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• татварын өргүй байх</li> <li>• зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн чадавхтай байх</li> <li>• мэдүүлэгчийн өмнөөс гаалийн болон холбогдох бусад татварыг төлөх, эсхүл төлөхөөр гаргасан баталгааг хангахад учирч болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор эрсдлийн сан байгуулсан байх</li> <li>• гаалийн хууль тогтоомжийн зөрчил гаргаж байгаагүйг нотолсон гаалийн болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт</li> </ul>
5	Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа	3 жил хүртэл
6	Улсын тэмдэгтийн тухай хууль	Тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу 850000 төг
7	Тэмдэгтийн хураамж төлөх	Дүүргийн татварын хэлтэст нэхэмжлэл үүснэ.
8	Эрсдлийн сангийн хэмжээ	2010 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.3 -т заасан Гаалийн болон бусад татвар төлөх, эсхүл татвар төлөхөөр гаргасан баталгааг хангахад учирч болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор 50,0 сая төгрөгөөс доошгүй эрсдлийн сан бүрдүүлсэн байх /компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө нь 50,000.0 мян.төгрөгөөс доошгүй байх тохиолдолд эрсдлийн сан бүрдсэн гэж үзнэ ;
9	Гаалийн хуулийн тогтоомжийн зөрчил гаргаж байгаагүй байх	Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх хэрэг бүртгэх газрын тодорхойлолт
10	цагдаагийн байгууллагын тодорхойлолт	ЦЕГ Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны тодорхойлолт
11	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн	Гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан иргэнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээ

		олгоно. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээний хугацаа хүчин төгөлдөр байх бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэгчийн албан ёсны ажилтан байх.
12	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний мэдүүлэг нөхөн бичих эрхийг хэрхэн нээлгэх	Тусгай зөвшөөрөл бүхий гаалийн зуучлагч аж ахуйн нэгж гаалийн харъяа газар хороодтой гэрээ байгуулна. Гаалийн байгууллагаас гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гаалийн гадаад портал системд /CEPS/ нэвтрэх эрх нууц үг олгоно.
13	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн сургалт	ГЕГ-ын дэргэдэх Хэвлэл мэдээлэл, Сургалт судалгааны төв дээр хэрэгцээ шаардлагыг харгалзан захиалгаар явагддаг. Сургалтын хугацаа 45 хоног.
14	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээний хугацаа	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээ сунгах давтан сургалтыг 2 жил тутам зохион байгуулна.
15	Зөвшөөрлийг ямар зорилгоор олгодог вэ?	Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийг бараа, тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй байгуулсан аж ахуйн гэрээний үндсэн дээр гаалийн байгууллагад мэдүүлэх ажлыг гаалийн зуучлагч төлөөлөн хийнэ. Гаалийн зуучлагч нь барааг ачихаас хүлээн авах хүртэлх замд гарч болох асуудлыг урьдчилан тооцож, валютын ханш, гаалийн татварын өөрчлөлт зэргийг ямар гаалийн зохицуулалтаар шийдэж болохыг импортлогч нарт зөвлөж, гаалийн байгууллагатай харьцахад аливаа хүндрэл гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.